



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/301

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.2.8 дахь заалтыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдийг ослын голомтоос лавлагаа шатлалын эмнэлэгт шуурхай шилжүүлэх төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



00003328

**ГАМШИГ, ОСЛЫН ҮЕД НЭРВЭГДЭГЧДИЙГ ОСЛЫН ГОЛОМТООС ДАВЛАГАА  
ШАТЛАЛЫН ЭМНЭЛЭГТ ШУУРХАЙ ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын хүн ам нь тархан суурьшсан, аймгийн төвөөс алслагдмал, сум, тосгонд байрлах эрүүл мэндийн анхан шатны нэгжүүдэд түлэгдэлт, гэмтэл, мэс заслын тусламж үзүүлэх боломжгүй, сэхээн амьдруулах, тогтворжуулах эмчилгээ хийх тоног төхөөрөмж хангалтгүй, эмч, эмнэлгийн мэргэжилтний хүрэлцээ дутмаг байна.

Энэхүү байдлаас шалтгаалан эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагаанд их хэмжээний цаг хугацаа зарцуулж байгаа нь гамшиг, ослын үед нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилах, эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээр нь үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагад агаараар болон газраар тээвэрлэн шилжүүлэх ажлыг бусад мэргэжлийн байгууллагатай хамтарч зохион байгуулах шаардлага гардаг. Сүүлийн 3 жилийн хугацаанд 5 аймгийн 6 сумын нутаг дэвсгэрт тохиолдсон зам тээвэр, гал түймэр, сураггүй алга болох зэрэг осолд 7 удаагийн агаараар болон төмөр замын тээвэрлэлтээр нийт 65 иргэнийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр Гамшгийн шуурхай удирдлагын газрын даргаар ахлуулсан шуурхай бүлэг бусад мэргэжлийн байгууллагатай хамтран Улаанбаатар хотод төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэгт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

**Хоёр. Зорилго**

Гамшиг, ослын үед нэрвэгдэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд оршино.

**Гурав. Хамрах хүрээ**

Энэхүү төлөвлөгөөг Монгол Улсын нийт нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн зарим хэсэгт, аюулт үзэгдэл, ослын улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэл үүссэн, амь нас хохирсон үед хэрэгжүүлнэ.

**Дөрөв. Хүрэх үр дүн**

Гамшиг, ослын үед нэрвэгдэгчдэд эрүүл мэндийн тусламж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, иргэдийн амь нас эрүүл мэндийг хамгаалах бэлэн байдал хангагдана.



Тав. Харилцан ажиллагааны зохицуулалт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх	Хугацаа
Нэг. Бэлэн байдал хангах чиглэлээр				
1.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд энэхүү төлөвлөгөөг хавсаргах	Аймаг, нийслэлийн ОБГ,	ОБЕГ, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги	Жил бүр
2.	Нэрвэгдэгсдийг шилжүүлэх (тээвэрлэх) нисдэг тэрэг, бага оврын нисэх онгоц буух талбайг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрт эрүүл мэндийн байгууллагад ойр байхаар бэлтгэх. Үүнд: Батлагдсан стандартын дагуу тэмдэгжүүлэх, гэрэлтүүлэх, тохижуулах, байрлалыг тодорхойлж бүртгэлжүүлэх, хамгаалах (сапхины чиг тодорхойлогч /wind socks/)	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Мэргэжлийн анги	Жил бүр
3.	Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн тооцоо, нөөцийн судалгааг хийх	Аймаг, нийслэлийн ОБГ	ОБЕГ, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги	Жил бүр
4.	Алсын дуудлагаар ажиллах нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнээс бүрдсэн багийг томилгоожуулах, хүний нөөцийг бэлтгэх (бэлтгэл баг)	Лавлагаа шатлалын эмнэлэг	ЭМЯ, Нийслэлийн эрүүл мэндийн газар	Тухай бүр
5.	Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний баг, техник, тоног төхөөрөмж тээвэрлэх эмнэлгийн зориулалтын автомашины бэлэн байдлыг хангах, хангалт, нөөцийг бүрдүүлэх	Лавлагаа шатлалын эмнэлэг	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	Жил бүр
6.	Цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, шаардлагатай тооцоо судалгаа хийх	ЦССУТ	ЭМЯ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	Тухай бүр
Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:				
7.	Гамшиг, ослын мэдээллийг хүлээн авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх	ОБЕГ	Аймаг, нийслэлийн ОБГ, ЭМГ, Лавлагаа шатлалын эмнэлэг	1 цаг



17.	Шуурхай ажлын хэсэг ажиллах нөхцөлийг бүрдүүлэх (ар тал, хангалтын)	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги	Тухай бүр
18.	Нэрвэгдэгсдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоо, тусламж, үйлчилгээг зохион байгуулах	Шуурхай ажлын хэсэг	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага	Тухай бүр
19.	Ослын голомтод ажиллах хүч хэрэгслийг хуваарилах, шаардлагатай хүч хэрэгслийг татан оролцуулах	ОБЕГ, Аймаг нийслэлийн Засаг дарга	ЭМЯ, Аймаг, нийслэлийн ОБГ, ЭМГ	Тухай бүр
20.	Үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар удирдах дээд байгууллагад тухай бүр мэдээлэх	ОБЕГ, Шуурхай ажлын хэсэг	Аймаг, нийслэлийн Онцгой комисс, Шуурхай бүлэг	Тухай бүрт
21.	Осолд өртөж нас барсан иргэдийг таниулах, тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Аймаг, нийслэлийн Онцгой комисс	ЦЕГ, ШШУХ	Тухай бүр
22.	Нэрвэгдэгсэд болон тэдний ар гэрийнхэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	СЭМҮТ, МУЗН	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги	Тухай бүр
Гурав. Нэрвэгдэгсдийг шилжүүлэх арга хэмжээний талаар:				
23.	Тээвэрлэх маршрут, нөөц маршрут, агаараар болон газраар, төмөр замаар холимог тээвэрлэлт хийх маршрутыг гаргах	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, Шуурхай ажлын хэсэг	ЗТХЯ, ЗХЖШ, Аймаг, нийслэлийн Засаг дарга, ОБГ, ЦУОШГ	24 цаг
24.	Ослын голомтод холбоо зохион байгуулах	ОБЕГ	БХЯ	Тухай бүр
25.	Нэрвэгдэгсдийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэлтээр суурилуулах (Жич: Хүчилтөрөгчийн баллон, дамнуурга)	Лавлагаа шатлалын эмнэлэг, ЗХЖШ	ЗХТЯ, ЭМЯ, Нийслэлийн эрүүл мэндийн газар, авиа компани	Тухай бүр
26.	Нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, биеийн байдлыг тогтворжуулах, тээвэрлэхэд бэлдэх	Шуурхай ажлын хэсэг	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	Тухай бүр
27.	Нэрвэгдэгсдийг тээвэрлэх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг	Шуурхай ажлын хэсэг	ЗТХЯ, ЗХЖШ, ОБЕГ,	Тухай бүр



зохион байгуулах	Тухайн орон нутгийн ЗДТГ	ЦУОШГ, авиа компани	бүр
28. Нэрвэгдэгсдийг шилжүүлэх явцад түр зогсолт хийх шаардлага гарсан тохиолдолд ар тал хангалтыг зохион байгуулах	Тухайн орон нутгийн ЗДТГ	ЗХЖШ, ОБЕГ, ЦУОШГ	Тухай бүр
29. Тээвэрлэгдэн ирсэн нэрвэгдэгсдийг эрүүл мэндийн байгууллагад хүргэх эмнэлгийн зориулалтын автомашинаар үйлчлэх	Нийслэлийн эрүүл мэндийн газар	ЭМЯ, ОБЕГ	Тухай бүр
30. Нисэх онгоцны буудал, авто болон төмөр замын вокзалын гадна талд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтыг зохион байгуулах	ЦЕГ	“Чингис хаан”, “Буянт-Ухаа” ОУНБ, УБТЗ ХНН	Тухай бүр
31. Нэрвэгдэгсдийг тээвэрлэх эмнэлгийн зориулалтын автомашиныг хөтөчлөн агаарын хөлгийн зогсоол болон төмөр замын зогсоолд хүргэх	ЗХЖШ, ИНЕГ, УБТЗ ХНН	ОБЕГ	Тухай бүр
32. УБТЗ-ын Улаанбаатар өртөө, “Чингис хаан” болон “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлаас цуваагаар явахад цагдаагийн хөтөч автомашин батлагдсан маршрутын дагуу хөдөлгөөн үйлдэх	ЦЕГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар, Мэдээлэл шуурхай удирдлагын төв	Тухай бүр
33. Нисэх буудал, авто болон төмөр замын вокзалаас эмнэлэг рүү тээвэрлэх үед замын хөдөлгөөний зохицуулалт хийх	ЦЕГ, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, ЗХУТ	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Тухай бүр
34. Нэрвэгдэгсдийг хүлээн авах эмнэлэг, ШШҮХ-нд урьдчилан мэдэгдэх, хүлээн авах бэлтгэлийг хангуулах	ОБЕГ	ЦЕГ, Лавлагаа шатлалын эмнэлэг	Тухай бүр
35. Хүлээн авах эмнэлэг, ШШҮХ-ийн хашааны гадна болон дотор талд үзлэг шалгалт хийх, хэв журам сахиулах эргүүл, хамгаалалт зохион байгуулах	ЦЕГ	Лавлагаа шатлалын эмнэлэг	Тухай бүр
36. Цогцос тээвэрлэх үед ашиглах уут, хайрцаг бэлтгэх	Аймаг, нийслэлийн Онцгой комисс	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги	Тухай бүр
37. Цогцос тээвэрлэх үеийн халдваргүйжүүлэлт, цогцост биологийн өөрчлөлт орохоос сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	МХЕГ, ШШҮХ	ЭМЯ, ОБЕГ	Тухай бүр
38. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ослын талаарх болон авч	ОБЕГ, Шуурхай ажлын	Хэвлэл мэдээллийн	Тухай бүр

Дөрөв. Бусад арга хэмжээний талаар:

	хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	хэсэг	байгууллагууд	бүр
39.	Үйл ажиллагааны тайланг гаргах, нэгтгэн дүгнэх, зарцуулсан зардлын тайлан гаргах	Аймаг, нийслэлийн Онцгой комисс	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги	Заагдсан хугацаан Д



НИСДЭГ ТЭРЭГ ЗАХИАЛАХ АЛБАН БИЧГИЙН ТӨСЛИЙН ЗАГВАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН  
ШТАБЫН ДАРГА, ..... ТАНАА

..... аймгийн ..... сумын нутаг дэвсгэрт гарсан  
(үүссэн нөхцөл байдал) иргэдэд эмнэлгийн яаралтай тусламж  
үзүүлэх зорилгоор Улаанбаатар-..... аймгийн ..... сум-  
Улаанбаатар хотын чиглэлд ..... оны ..... дугаар сарын .....-ны өдөр нисдэг тэрэг  
гаргаж ажиллуулна уу.

ДАРГА,

.....

.....

ГАМШИГ, ОСЛЫН ҮЕД НЭРВЭГДЭГСДИЙГ ОСЛЫН ГОЛОМТООС ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ЭМНЭЛЭГТ ШИЛЖҮҮЛЭХ  
АЖИЛЛАГААНЫ ЦАГИЙН МЭДЭЭ

Д/д	Он, сар, өдөр	Явах чиглэл	Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн	Шүүрхай ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Бусад бүрэлдэхүүн	Аяллын дугаар	Тээврийн хэрэгслийн дугаар	Хөөрсөн /хөдөлсөн/ цаг	Тооцоот цаг	Суултын /очсон/ цаг	Тайлбар

Ерөнхий зохицуулагч.....



15	Асуудал хариуцсан ажилтан	-	томилох	-
16	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн		Цогцос таниулах, хадгалах	264018
17	Асуудал хариуцсан ажилтан	-		-

(Тухайн байгууллагын асуудал хариуцсан албан тушаалтны утсыг жил бүр тодотгох)